

Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

Ти Ди Би Секьюритис ҮЦК нь харилцагчийн санхүүгийн болон хувийн мэдээллийг нууцлал, бүрэн бүтэн, хүртээмж-ийг хангах зорилгоор мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон ISO/IEC 27001:2022, NIST Cybersecurity Framework, PCI-DSS зэрэг стандарт, сайн туршлагыг баримтлан ажилладаг.

Харилцагчид өгөх баталгаа

- Өгөгдлийг ангилан хамгаална (Нээлттэй/Дотоод/Маш нууц) бөгөөд “Маш нууц” өгөгдлийг шифрлэн хадгалж, дамжуулах үед TLS хамгаалалт ашиглана.
- Хандалтын хяналттай: ажил үүрэгт зайлшгүй шаардлагатай хэмжээнд эрх олгож, RBAC-аар зохицуулна. Системийн админ үйлдэл хяналттай бөгөөд бизнесийн мэдээлэл рүү шууд хандахгүй.
- Албан ёсны сувгийг ашиглаж, бүх албан ёсны системд нэвтрэхдээ 2 алхамт баталгаажуулалт хэрэглэнэ.
- Төлбөрийн өгөгдөл хамгаалалт: картын PIN, CVV/CVC-г системдээ хадгалахгүй, карт/дансны дугаарыг далд хэлбэрээр харуулж, төлбөрийн өгөгдөл боловсруулах сүлжээг тусгаарлана.
- Тохиолдол ба мэдэгдэл: харилцагчийн мэдээлэлд эрсдэл учирсан тохиолдолд боломжит хамгийн богино хугацаанд ойлгомжтой тайлбарлаж, эрсдэлийг бууруулах зааварчилгааг өгнө. Эмзэг мэдээлэл эрсдэлд орсон тохиолдолд 72 цагийн дотор мэдэгдэнэ.
- Харилцагчийн мэдээллийн эрхийг хүндэтгэнэ: мэдээлэлтэй байх, мэдээлэлдээ хандах, засуулах зэрэг эрхүүдийг хангана (баталгаажуулалтаас хойш ажлын 3 хоногийн дотор засвар/шинэчлэлт хийх зохицуулалттай).
- Нууц мэдээллийн хамгаалалт: харилцагчийн хувийн мэдээлэл зэрэг нууц мэдээллийг нийтийн хиймэл оюун ухааны платформ руу хуулах/оруулах/боловсруулахыг хориглоно.